

ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
2.9 ТЭРБУМ ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
8.3%



НИЙТ ХАДГАЛАМЖ
11.4 ИХ НАЯД ТӨГ



ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС
1.027 НЭГЖ



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
937 ТЭРБУМ ТӨГ



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
10%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +3.8%, 2019 онд: +4.3%
 Инфляци: 2018 онд: +8%, 2019 онд: +7%
 Урсгал тэнцэл: 2018 онд ДНБ-ий -6.3%, 2019 онд: -7%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2018 он 4-р сарын тайландаа тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2HJFlip>


ДНБ-ий өсөлт: 2018 онд: +5%, 2019 онд: +6.3%
 Инфляци: 2018 онд: +6.4%, 2019 онд: +6.8%,
 ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2018 онд: -6.4%, 2019 онд: -8.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2018 он 4-р сар) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 4-р сарын байдлаар 98.1 тэрбумын ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 19 хувиар өсч, зарлага 0.6 хувиар өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 98.1 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 65.6 хувиар буурсан байна.




Ам.долларын ханш өмнөх сараас буурсангүй.

Дөрөвдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 27 төгрөг буюу 1.1 хувиар буурч, өмнөх сартай харьцуулахад 0.7 төгрөгөөр буурч 2394.65 төгрөг болов. 4-р сард гадаад валютын нөөц 2.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3 дахин нэмэгдсэн байна.




Инфляцийн түвшин 6%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2018 оны 4-р сарын байдлаар өмнөх сараас 0.6 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 6 хувиар өсөв. Тус сард ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, орон сууцны, цахилгаан болон хийн түлшний үнэ хамгийн их өсөхөд нөлөөлсөн байна.



Гадаад худалдааны тэнцэл 351.9 сая.ам доллар болов.

2018 оны гуравдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 2612 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 25 хувиар өссөн бол экспорт 14 хувиар нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 45 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 351.9 сая ам.долларын ашигтай гарлаа.



4-Р САРЫН ОНЦЛОХ: ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДНБ 2018 оны 1-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 3.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17,061 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 6.1% өсөв. Бүтээгдэхүүний цэвэр татвар 16%, үйлчилгээний салбар 5% өссөн нь голлон нөлөөлөв. Статистикийн хорооны тооцооноос харахад өнгөрсөн оны мөн үед эдийн засгийн өсөлт (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 126.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 4.3% болсон. Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 8%-иар буурсан бол, үйлчилгээний салбар 6%-иар өсчээ.

Улирлын нөлөөллийг арилган тооцооноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны эхний улиралд өмнөх улирлаас 1.6 хувиар өслөө. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2018 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 6.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 864.6 (15.6%) тэрбум төгрөгөөр өслөө. Харин эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 3.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 188.1 (6.0%) тэрбум төгрөгөөр өсөв. Уг өсөлтөд экспорт 506.7 (18.6%) тэрбум төгрөг, үндсэн хөрөнгийн нийт хуримтлал 303.9 (48.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

САРЫН ОНЦЛОХ: ОРОН СУУЦНЫ ҮНЭ ӨСӨВ, АХБ-ААС 2.5 САЯ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ

- Нийслэлийн 6 дүүрэгт орон сууцны үнэ 2018 оны эхний улиралд 2010 оны эцсээс 82.1 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурсан үзүүлэлт гарав. Орон сууцны үнэ нэгдүгээр улиралд өмнөх оны мөн үеэс Сонгинохайрхан дүүрэгт 0.8 хувь, Баянгол дүүрэгт 0.6 хувь, Баянзүрх дүүрэгт 0.4 хувь, Хан-Уул, Сүхбаатар болон Чингэлтэй дүүрэгт 0.3 хувиар буурсан байна.
- Азийн хөгжлийн банк (АХБ), Ядуурлыг бууруулах Японы Сангаас Монгол Улсад 2.5 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэх болж, санамж бичигт гарын үсэг зурлаа. Уг тусламжийн нэг сая ам.доллараар Монгол Улсын усны засаглалыг бэхжүүлэх чиглэлд техникийн туслалцаа үзүүлэх юм. Энэ хүрээнд усны засаглалын чиглэлээр одоо хэрэгжиж буй стандартуудад үнэлгээ хийж, хууль, эрхзүйн орчныг сайжруулахад чиглэсэн зөвлөмж боловсруулахаас гадна томоохон голуудын сав газрын менежментийн төлөвлөгөөг шинэчлэх юм. Харин 1.5 сая ам.доллараар "Аймаг, сумын төвүүдэд зориулсан бүсийн хөгжлийн техникийн туслалцааны төсөл" хэрэгжүүлэх бөгөөд зарим аймаг, сумын нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг сайжруулах, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чиглэлд Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 4-р сар 2018 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 4-р сар 2018 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn